

САЙН ТУРШЛАГА 2017 АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн эрүүл мэндийн газраас зохион байгуулж буй Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тусламж, үйлчилгээний САЙН ТУРШЛАГА шалгаруулах өдөрлөг Өргөө амаржих газар 2017оны 10 сарын 5 өдөр 9:00 цагт эхэллээ.

Тус арга хэмжээнд 24 байгууллагын 148 бүтээл оролцсоноос эхний 5 бүтээлийг шалгаруулж өргөмжлөл, эхний 20 бүтээлд гэрчилгээ олгосон юм.

Хан-Уул эрүүл мэндийн төв нь эмчилгээний шинэ технологи, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хөнгөвчлөх дараах бүтээлүүдээр оролцлоо.

- Сэргээн засах эмчилгээ буюу KINESIO TAPING;
- Эмгүй хатгах эмчилгээ буюу DRY NEEDLING;
- Ахуй заслын хэрэгсэл;
- Эмч, эмнэлгийн ажилчдын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд ашиглах гарын авлага;
- ӨЭМТ-д нярайн шарлалт тодорхойлох аппаратыг ашигласан туршлага;
- Артерийн гипертензийн өвчтөний хяналтыг сайжруулахын тулд хяналтын картыг шинээр боловсруулж ашигласан туршлага;

Эдгээр бүтээлүүдээс Эмгүй хатгах эмчилгээ буюу DRY NEEDLING эмчилгээний арга технологи 7 дугаар байранд шалгарсан билээ.

